

**“ДАРХАН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨААТҮГ-ЫН  
АЖИЛТАН АЛБАН ХААГЧДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮН ТООЦОЖ,  
ДҮГНЭХ УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1 Дархан Үйлдвэрлэл Технологийн Парк ОНӨААТҮГ-ын ажилтан албан хаагчдын үндсэн цалингийн хэмжээг тогтоох, ажлын бүтээмжийг үнэлж, дүгнэх, урамшуулал олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.
- 1.2 Урамшуулал олгох нь тухайн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан үүрэг, ажлын идэвх санаачлаг болон удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн хэрэгжилтийн үзүүлэлт болно.
- 1.3 Ажилтны үндсэн цалинг тогтоохдоо Дархан Үйлдвэрлэл Технологийн Парк ОНӨААТҮГ-ын дүрмийн 7.1.6, Хөдөлмөрийн дотоод журмын 4.1.10, 4.1.11, 9.1 дэх заалтуудыг үндэслэн тогтоож, хөдөлмөрийн гэрээнд тусгана.
- 1.4 Урамшуулал олгохдоо Дархан үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын дүрмийн 7.1.8, 7.1.10, Хөдөлмөрийн дотоод журмын 9 зүгээр зүйлийн 9.7, 9.8 дугаар заалтуудыг үндэслэн шударга ил тод зарчмыг баримтална.

**Хоёр. Хамрах хүрээ**

- 2.1 Сар бүрийн эцэст хийсэн ажлын тайланг Дархан үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын ажилчдын хурлаар хэлэлцүүлж баталгаажуулна.
- 2.2 Ажил дүгнэх шалгуур нь тухайн жилдээ хүчинтэй байх бөгөөд дараа жилийн зорилт, тухайн жилийн зөрчил дутагдлаас хамааран түүнийг сайжруулах зорилгоор нэмэлт өөрчлөлт оруулж болно.

**Гурав. Дүгнэх аргачлал**

- 3.1 Ажил дүгнэх шалгуур  
Ажилтны ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөний гүйцэтгэл, өгсөн үүрэг даалгаврын биелэлт зэрэг нь тус бүр оноо өгч дүгнэнэ.
  - 3.1.1 Ажилтны ажлын төлөвлөгөө гарган батлуулсан байдал -20 оноо
  - 3.1.2 Ажилтны ажлын төлөвлөгөөний биелэлт -30 оноо
  - 3.1.3 Өгсөн үүрэг даалгаврын биелэлт -20 оноо
- 3.2 Цаг ашиглалт таслалт, хоцролт, ажлын цаг ашиглалт -20
- 3.3 Бусад -10 оноо
- 3.4 Оноо нь:
  - 3.4.1 90-100 оноо авсан бол “Маш сайн”
  - 3.4.2 80-89 хүртэл оноо авсан бол “Сайн”
  - 3.4.3 70-79 хүртэл оноо авсан бол “Хангалттай”
  - 3.4.4 0-69 хүртэл оноо авсан бол “Хангалтгүй”
- 3.5 Ажилтан тухайн сарын ажлын тайлан, дараа сарын ажлын төлөвлөгөөг сар бүрийн 03-ны дотор өгч, Мэдээлэл технологийн мэргэжилтэн нэгтгэн даргад танилцуулна, Газрын дарга үнэлгээ өгч батална.

**Дөрөв. Шагнал урамшуулал**

- 4.1 70-с дээш буюу “Хангалттай” гэсэн үнэлгээ болон түүнээс үнэлэгдсэн ажилтанд Улирлын урамшууллыг олгоно.

- 4.2 70-с дээш буюу “Хангалттай” гэсэн үнэлгээ болон түүнээс үнэлэгдсэн ажилтанд хагас болон бүтэн жилийн урамшуулал олгоно.
- 4.3 Жилийн эцэст арван хоёр сарын нийт дүнгийн үзүүлэлтийн дундаж 85-с дээш, хамт олны хурлын олонх-ийн санал авсан ажилтанд ДҮТПарк ОНӨААТҮГ-ын оны шилдэг ажилтнаар шалгаруулна.
- 4.4 Үндсэн ажилтнаар томилогдон 6 сараас дээш хугацаанд ажилласан ажилтанд урамшууллыг бодож олгоно.

#### **Тав. Хариуцлага**

- 5.1 Сарын эцэст 0-69 оноо авсан ажилтны асуудлыг ажилчдын хурлаар оруулж шийдвэрлэнэ.
- 5.2 Хоёр /2/ сар дараалан 0-69 оноо авбал сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно.
- 5.3 Жилд нийт гурав /3/ сар дараалан 0-69 оноо авбал хөдөлмөрийн гэрээ цуцлах үндэслэл болно.
- 5.4 Тайлант хугацааны дундуур ажилтан өөр албан тушаалд шилжсэн, чөлөөлөгдсөн тохиолдолд ажилласан хугацааны ажлын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэнэ, шинээр томилогдсон ажилтан ажлын төлөвлөгөөний биелэлтийг үргэлжлүүлэн хангаж сар, улирал, бүтэн жилээр тайлагнана.
- 5.5 Ажилтан, газрын дарга албаны дарга өгсөн үнэлгээтэй санал нийлээгүй тохиолдолд 360 градусын үнэлгээний аргаар дахин үнэлнэ. Дахин үнэлсэн үнэлгээг шууд тооцно.

“Дархан үйлдвэрлэл технологийн парк”  
ОНӨААТҮГ-ын даргын 01-ны 01 дүгээр  
сарын 05-ны өдрийн 16 дүгээр  
тушаалын хавсралт 2




Албан тушаал, ажилтан /...../-ы гүйцэтгэлийн үр дүн тооцож,  
дүгнэх хуудас

| д/д | Ажилтан албан<br>хаагчдын ажил<br>дүгнэх,<br>урамшуулал<br>олгох журам | Үнэлэх<br>оноо | Нийт<br>үнэлгээнээс<br>авах оноо | Үнэлгээнээс<br>авсан<br>оноо | Үнэлгээний<br>чанар | Урамшууллын<br>хэмжээ /хувь/ |
|-----|------------------------------------------------------------------------|----------------|----------------------------------|------------------------------|---------------------|------------------------------|
| 1   | Журмын 3.1                                                             | 70             | 100                              | 90-100                       | Маш сайн            | 40%                          |
| 2   | Журмын 3.2                                                             | 20             |                                  | 80-89                        | Сайн                | 35%                          |
| 3   | Журмын 3.3                                                             | 10             |                                  | 70-79                        | Хангалттай          | 25%                          |



“Дархан үйлдвэрлэл технологийн парк”  
ОНӨААТҮГ-ын даргын 104/оны 0/ дүгээр  
сарын 15-ны өдрийн 1/дүгээр  
тушаалын хавсралт 3



### Үндсэн ажилтны цалингийн хэмжээ

| д/д | Албан тушаалын нэр                                    | Мэргэжил                                             | Боловсрол             | Үндсэн цалингийн хэмжээ |
|-----|-------------------------------------------------------|------------------------------------------------------|-----------------------|-------------------------|
| 1   | Дарга                                                 | Эдийн засагч, Хууль, эрх зүйч, Инженер, Технологич   | Бакалавр түүнээс дээш | 1.000.000-1.500.000     |
| 2   | Нягтлан                                               | Нягтлан бодогч                                       | Бакалавр түүнээс дээш | 700.000-1.200.000       |
| 3   | Мэдээлэл технологи, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | Програм хангамж, эрх зүйч                            | Бакалавр түүнээс дээш | 700.000-1.200.000       |
| 4   | Хөрөнгө оруулалт, судалгааны мэргэжилтэн              | Эдийн засаг, статистик                               | Бакалавр түүнээс дээш | 500.000-1.000.000       |
| 5   | Архитектор                                            | Архитектор                                           | Бакалавр түүнээс дээш | 700.000-1.200.000       |
| 6   | Барилгын инженер                                      | Барилгын инженер                                     | Бакалавр түүнээс дээш | 700.000-1.200.000       |
| 7   | Үйлдвэрлэл технологийн мэргэжилтэн                    | Эдийн засагч                                         | Бакалавр түүнээс дээш | 700.000-1.200.000       |
| 8   | Хэсэгчилсэн төлөвлөлт, дэд бүтцийн инженер            | Хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын мэргэжилтэн | Бакалавр түүнээс дээш | 700.000-1.200.000       |